

## ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ БЭЛТГЭХ АСУУДАЛД

Г. Билгүүн\*

\* Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн ахлах мэргэжилтэн, магистр

**Түлхүүр үг:** эрх зүй, сэтгүүл зүй, гэмт хэргийн мэдээлэл, эрх зүйн мэдээлэл

### Эрх зүйн мэдээллийн тухай ойлголт

**М**онголын урлагийн охь дээж, сод бүтээл гэгдэх “Учиртай гурван толгой” дуурьтай адил эрх зүйн шинжлэх ухааны хэзээ ч хуучиршгүй, охь болсон Ромын дигест “ius est ars boni et aequi” буюу “Эрх зүй гэдэг бол шударга ёсонд тэмүүлэх, шударга ёс, тэгш ёс хоёрын хөл нийлүүлэх урлаг мөн” гэсэн тодорхойлолтоор эхэлдэг нь санамсаргүй зүйл биш ажээ. Угаас эрх зүй бол шударга ёс, эрх тэгш байдлаас урган гардаг.

Хүн бүр хүмүүний энэрэл, гэгээрлийн дээд түвшинд хүрч, цэвэр ариун сэтгэлтэй байж шударга ёсны төлөө бие, сэтгэлээ золих боломжгүй. Тиймдээ ч давын өмнө өөрийн эрх ашгийг хичээдэг. Үүнээс үүдэн тэгш бус байдал үүсч, бусдыг эрхийг зөрчдөг байна. Чухам энэ үед “эрх зүй” үүргээ биелүүлж нийгмийн ярвигтай харилцааг зохицуулж, хүний эрхийг хамгаалан, бататгаж, нийгмийн сайн сайхны төлөө “зүтгэдэг”.

Дээр дурдсанчлан эрх зүйг хууль хэмээн тайлбарладаг байсан цаг саяхан. Тиймдээ ч олон нийтийн мэдээллийн хэрэгслээр эрх зүйн мэдээлэл хүргэхийг хууль хэвлэх төдийхнөөр ойлгодог байв. Энэ хандлага одоо ч хэвээр хадгалагдан буй нь харамсалтай. Тухайлбал “Зууны мэдээ”, “Өдрийн сонин” зэрэг сонин аливаа хууль батлагдан гарахад хэд хэдэн нүүр дамнуулан уг хуулийг бүрэн эхээр нь хэвлэх тохиолдол ажиглагдсаар байна. Хууль болон эрх зүйн мэдээлэл нь өөр агуулгатай тухай эртний түүхээс харж болох юм. Нюрнбергийн шүүх хурал эл жишээг баталж өгнө. Энэ нь дур зоргоор батлан гаргасан олон тооны “шударга бус” хуулиар еврей иргэдийг шүүсэн бөгөөд шударга ёсонд харш байсан ч зөвхөн хуулийг дагаж мөрдөх учиртай гэсэн тайлбараар олны амыг хааж байв. Энэ тухай хуульч Густав Радбух “шүүгчийг шударга ёсыг үл харгалзан зөвхөн хууль хэрэгжүүлэх үүрэгтэй утсан хүүхэлдэй болгодог” хэмээн тэмдэглэсэн байдаг.

Тиймээс хуулийг хэвлэх төдийхнийг эрх зүйн мэдээлэл гэх нь өрөөсгөл ойлголт юм. Эрх зүйн мэдээллийн нэг салшгүй хэсэг нь хууль, эрх зүйн акт мөн ч зөвхөн хуулиар үл хязгаарлагдах

асар том мэдээллийн орон зай бол эрх зүйн мэдээлэл билээ.

Эрх зүйн мэдээлэл (англиар legal information, оросоор правовая информация)-ийг "өргөн утгаараа эрх зүйн аливаа нэгэн зорилтын талаар шийдвэр гаргахад ашигладаг буюу түүнийг шийдвэрлэхэд тус дөхөм үзүүлдэг мэдээ сэлтийн агуулга"<sup>1</sup> хэмээн тодорхойлсон байдаг. Судалгааны болон хууль зүйн ном зохиолд энэ нэр томъёог 1960-аад оны сүүлчээс өргөн хэрэглэж эхэлсэн бөгөөд энэ нь харьцангуй шинэ ойлголт гэдгийг харуулж буй юм. Цаг хугацааны хувьд тус ойлголт эрх зүйн тодорхой зорилтыг шийдвэрлэхэд компьютерыг ашиглах судалгааны үетэй давхцдаг байна. Эрх зүйн мэдээллийн анхдагч гэж хэвлэмэл хууль болон замын хөдөлгөөний дүрмийг таниулах тэмдэглэгээ, санамж бичиг зэргийг нэрлэдэг тохиолдол ч бий.

Хууль тогтоомжийг олон нийтэд мэдээлэх, таниулах, сурталчлах нь хүн төрөлхтөн төр, засаглалын хэлбэртэй болсноос эхэлжээ. МЭӨ IV мянганы үед Египетийн хаад, эздийн зарлигийг ард иргэдэд мэдээлэх, хүргэх, сурталчлах зорилгоор хад чулуу, модон дээр сийлэн олон нийтийн газар байрлуулж байсан тухай хууль, эрх зүйн хөгжлийн сурвалжид тэмдэглэсэн байдаг.

Мөн МЭӨ I зуунд эртний Ромд төрийн зөвлөл байгууллага болох Сенатын шийдвэрийг самбарт бичин олны хүртээл болгож байсан нь эрх зүйн талаарх мэдээллийг нийтэд хүргэж байсан жишээ юм. Эдгээр баримт нь тухайн үеийн хаад, эздийн зарлиг, шийдвэрийг ард олонд таниулан сурталчлах зорилготой эрх зүйн мэдээллийн анхдагч байв.

Эзэн хааны зарлиг, шийдвэрийг иргэдэд хүргэх зорилготой сонин Хятадад гарч байсан бөгөөд үүний нэг нь "Бодорул дэвшүүлэх хүрээлэнгийн Зуан" сонин юм. Тус сонин зорилго нь хязгаар нутгийн засаг захиргааны ноёдод нийслэлийн сураг зангийг мэдээлэх явдал байжээ. Үүнд хааны өдөр тумын амьдрал байдал, Засгийн газрын зарлиг, заавар, зарлал, айлтгал, ноёд түшмэдээс хаанд өргөсөн бодорул бичиг, ноёд тушаалд дэвшсэн ба тушаалаас огцорсон тухай болон хязгаарын захиргааны ашиг тусад харшилсан хэрэг явдал тусгагддаг байжээ<sup>3</sup>.

**М**онгол туургатны анхны хэвлэл болох "Дорнод хязгаарын амьдрал" сонин нийт 450 дугаар гарахдаа "Засгийн газрын албан мэдээ", "Дорнод хязгаартай хөрш орны тухай" буландаа Оросын хааны зарлиг, Засгийн газрын шийдвэр, шүүн таслах үйл ажиллагааны мэдээлэл зэргийг нийтэлж байв.

Харбин хотод хэвлэгдэн гарч байсан "Монголын сонин бичиг"-т Ж.Цэвээн, Д.Бодоо нар "Монголын шинэ сонсгол", "Шүүмжлэн өгүүлсэн нь" зэрэг өгүүлэлдээ хууль цааз амьдралд хэрхэн хэрэгжиж байгаад шүүмжлэлтэй хандан бичдэг байжээ.

Эрх зүйн мэдээлэлд юуны түрүүнд эрх зүйн актыг, мөн эрх зүйтэй холбоотой бүхий л мэдээллийг багтааж болно. Үүнд: хууль, хуулийн төсөл болон бусад хэм хэмжээний эрх зүйн акт, тэднийг хэлэлцүүлэх ба батлах үеийн мэдээлэл, эрх зүйн хэм хэмжээний тайлбар ба хэрэгжүүлэлт, тэднийг хэрэглэх практик судалгаа зэрэг орно. Эрх зүйн мэдээлэлд мөн эрх зүйн боловсролын тухай, эрх зүйн

хөгжлийн шинжлэх ухааны үзэл баримтлалыг боловсруулах тухай материалыг багтааж үздэг олон улсын хандлага байна. Энэ бүхнээс харахад эрх зүйн мэдээлэл бол нэлээд өргөн хүрээний, түвэгтэй ойлголт юм. Өөрөөр хэлбэл эрх зүйн мэдээлэл гэдгийг эрх зүйн актууд болон түүнтэй холбоотой эрх зүйн үйл ажиллагааны бүх хүрээг хамарсан мэдээлэл лавлагааны, шинжлэх ухааны материалууд хэмээн ойлгож болно.

Эрх зүйн мэдээллийг түүний "зохиогч" хэн гэдгээс хамааран, өөрөөр хэлбэл түүнийг хэн буй болгож, хаашаа чиглэгдсэн гэдгээс хамааран гурван том бүлэгт хуваадаг. Үүнд:

- Эрх зүйн албан ёсны мэдээлэл
- Эрх зүйн шинжтэй мэдээлэл (эрх зүйн үр дагавартай)
- Эрх зүйн албан бус мэдээлэл зэрэг багтана.

*Эрх зүйн албан ёсны мэдээлэл гэдэг нь эрх бүхий төрийн байгууллагаас өгсөн эрх зүйн учир холбогдолтой, нийгмийн харилцааг зохицуулахад чиглэгдсэн мэдээлэл юм.*

*Эрх зүйн шинжтэй мэдээлэл гэдэгт нь захирах эрхийг эдэлдэггүй эрх зүйн янз бүрийн субъектээс гарсан ба тодорхой эрх зүйн харилцааг зохицуулахад (өөрчлөх, дуусгавар болгох) чиглэгдсэн мэдээлэл багтана.*

*Эрх зүйн албан бус мэдээлэл гэдэг нь эрх зүйн үр дагаваргүй бөгөөд эрх зүйн хэм хэмжээг үр ашигтайгаар хангах, эрх зүйн аливаа асуудлын тухай мэдээлэлтэй байх, эрх зүйн суурь мэдлэг, соёлыг олгох болон хуулийн хэрэгжилтийн тухай мэдээ, мэдээлэл мөн.*

Дээрх ангиллаас харахад өнөөдрийн Монголын тогтмол хэвлэлд

ажиглагдаж буй хандлага нь эрх зүйн албан болон эрх зүйн шинжтэй мэдээллийг олон нийтэд хүргэж байна. Угтаа хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нь эрх зүйн албан бус мэдээллийг чухалчлах нь зүй юм. Хэдий хууль тогтоомж, эрх зүйн акт нь эрх зүйн мэдээллийн нэгэн хэсэг боловч хүлээн авагчдын сонирхолд хууль бүхлээрээ шаардлагатай бус, харин тухайн хуулийн өөрт хамаарах хэсэг энгийн ойлгомжтой байдлаар байх нь бодит хэрэгцээ шаардлага билээ.

#### **Эрх зүйн мэдээлэл энгийн байх нь**

Хүн амын ихэнх хэсэг нь бичиг үсэггүй байх үед эрх зүйн мэдээлэл амаар түгдэг байжээ. Ихэнх эрх зүйн дүрэм, журам нь зүйр цэцэн үгс шиг байсан ба түүнийгээ эрх зүйн хэлц гэж нэрлэдэг байв. Эрх зүйн тогтолцоот улсад галзуу хүн эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгддөг. Иймээс энэ тухайд гарсан эрх зүйн хэлц нь "галзуу солиотой хүн өөрийнхөө тэр галзуу байдлаараа шийтгэгдэж байгаа юм" гэсэн үг байдаг. Мөн монголчуудын "Хэнд гэм байна, түүнд зэм өг" хэлц эрх зүйн агуулгатай ажээ.

Хүлээн авагчдад хуулийг тэр чигт нь хэвлэн хүргэх нь үр дүн багатай, муу арга гэж хэлж болно. Зүйрлэвэл, тоо мэддэггүй хүүхдэд үржүүлэхийн хүрд заах, үсэг мэддэггүй хүнд өгүүлбэрийн найруулга ярихтай адил юм.

Монгол Улсад хууль дээдэлсэн ардчилсан нийгмийг хөгжүүлж, эрх зүйт төрийг төлөвшүүлэх нэг хүчин зүйл бол ард иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлэх явдал билээ. Манай орны нийгмийн бүхий л салбарын харилцааг зохицуулсан асар

олон хууль тогтоомж шинээр батлагдаж, мөн богино хугацааны дараа өөрчлөгдөн шинэчлэгдэж байгаа нь иргэд энэхүү хууль тогтоомжуудыг тухай бүр судалж, мэдэж, амьдралдаа хэрэгжүүлэх, сахин биелүүлэхэд сөргөөр нөлөөлж байна. Мөн манай улсын газар нутгийн хэмжээ, хүн амын нягтралын түвшин, дэд бүтцийн хөгжил зэрэг нь эрх зүйн мэдээлэл өгөх, эрх зүйн боловсрол олгох ажилд бэрхшээл болж байгаа юм.

Мэдээллийг хүртээмжтэй хэлбэрээр өгөх нь сэтгүүл зүйн салбарын туслалцаа шаардлагатайг харуулж буй юм. Өөрөөр хэлбэл ОНМХ-ийг, түүний нөлөөлөх чадварыг чадварлагаар ашиглах шаардлага бодит зүйл болсныг илтгэж байна. Мэдээллийн үнэ цэн, хүчний тухай эрдэмтэд олон тодорхойлолт өгсөн байдаг. Тухайлбал, "мэдээлэл нь энерги, матери хэмээх ойлголттой эн зэрэгцэхүйц"<sup>3</sup> хэмээн доктор, профессор М.Зулькафиль тодорхойлжээ. Тиймээс ОНМХ-ээр дамжин хүлээн авагчдад хүрч буй аливаа мэдээллийн үнэ цэн, нөлөөлөх чадварыг өөр зүйлтэй харьцуулашгүй.

Иргэдэд хууль, эрх зүйн мэдээлэл өгөх нь тэднийг төрийн хуулийг дээдлэн сахих, хуулиар олгогдсон эрхээ эдэлж, үүргээ биелүүлэх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах чадвартай болгох, нийгмийн амьдралд эрх зүйн өндөр ухамсар, сайн мэдээлэлтэй оролцох, нийгмийн аливаа

сөрөг үзэгдлийг багасгах зэрэг олон талын ач холбогдолтой.

ОНМХ бол эрх зүйн мэдээллийн үндсэн түгээгч юм. Үүнд уламжлалт хэвлэл (сонин, сэтгүүл), олон нийтийн мэдээллийн цахим хэрэгсэл (компьютерийн эрх зүйн тогтолцоо, радио, телевиз) багтана. Эдгээр эрх зүйн

«  
*Хэдий хууль тогтоомж, эрх зүйн акт нь эрх зүйн мэдээллийн нэгэн хэсэг боловч хүлээн авагчдын сонирхолд хууль бүхлээрээ шаардлагатай бус, харин тухайн хуулийн өөрт хамаарах хэсэг энгийн ойлгомжтой байдлаар байх нь бодит хэрэгцээ шаардлага билээ.*  
 »

мэдээллийг дэлгэрүүлэх аргуудаас аль нь илүү тохиромжтой, ирээдүйтэй вэ? Эрх зүйн мэдээллийг түгээхэд олон нийтийн мэдээллийн янз бүрийн хэлбэрийг ашиглах, хөгжүүлэх урьдчилсан төлөв таамаг ямар байна вэ? Эдгээр асуудлаар шинжээчид, хэрэглэгчид маргалддаг. Үүний зэрэгцээ энэ салбарт олон бодит асуудлыг цаг тухайд нь үр ашигтай шийдвэрлэх, нэн түрүүнд хэм хэмжээний эрх зүйн актыг шуурхай, чанартай, албан ёсоор нийтлэх ажлын зохион байгуулалтыг шийдвэрлэхэд олон нийтийн мэдээллийн хэлбэрүүдийг хөгжүүлэх нь чухал юм.

### Гэмт хэргийн мэдээлэл эрх зүйн мэдээлэл биш болох нь

Тогтмол хэвлэлд нийтлэгдэж буй цагдаагийн газраас бэлтгэн өгсөн, эсвэл гэмт хэргийн статистик мэдээллийг эрх зүйн мэдээлэл хэмээн нэрийдэх нь элбэг байдаг. Тиймдээ ч өдөр тумын сонин нийт материалд хийсэн задлан шинжилгээнд хууль, эрх зүйн мэдээллийн эзлэх хувь өндөр дүнтэй гардаг. Харамсалтай нь энэ нь

хөөсөн үзүүлэлт гэж хэлж болохоор байна.

Цаг үеийн өнгө байдлыг үзэхэд эрүүгийн хэрэг шийдвэрлэж буй субъект, тэдний удирдах албан тушаалтнуудаас байцаан шийтгэх ажиллагааны нууцалбал зохих баримтыг задруулснаар тухайн хэргийг шийдвэрлэхэд ихээхэн хүндрэл, бэрхшээл учруулдаг. Тиймээс эрэн сурвалжлах сэтгүүл зүй, ХМХ-ийн өрсөлдөөнөөс хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын мэдээ баримтыг хамгаалах, нууцлах шаардлага хурцаар тавигдаж байна. Олон нийтэд мэдээлэгдэж байгаа гэмт хэргийн талаарх мэдээлэл, нотлох баримт, түүнийг шийдвэрлэж байгаа процесс, хувь хүн, байгууллагын нууцлалыг хэрхэн хамгаалах, ямар арга хэрэгсэл ашиглах, ХМХ-тэй хуулийн байгууллага хэрхэн харилцах, нууцлал задруулсан этгээдэд хүлээлгэх хариуцлага гээд олон асуудал тодорхойгүй байгаа нь сэтгүүлчид энэ талаарх чанартай, үнэн бодит мэдээллийг хүлээн авагчдад хүргэхэд бэрхшээл учруулж буй бодит хүчин зүйл билээ.

**Г**эмт хэргийн статистик мэдээлэл бол эрх зүйн мэдээлэл биш. Эрх зүйн мэдээлэл нь эрх зүйн хэм хэмжээг үр ашигтайгаар хангах, эрх зүйн аливаа асуудлын тухай мэдээлэлтэй байх, эрх зүйн суурь мэдлэг, соёлыг олгох болон хуулийн хэрэгжилтийн тухай мэдээ, мэдээлэл мөн. Энэ үүднээс авч үзвэл гэмт хэргийн мэдээлэл нь эрх зүйн соёл, мэдлэгийг төлөвшүүлэхгүй, харин ч нийгмийн сэтгэл санаанд сөргөөр нөлөөлж болох хор уршигтай.

Эрх зүйн мэдээлэл хэмээн ташаарч гэмт хэргийн мэдээллийг сэтгүүлчид хэвлэн нийтэлж буй нь өөрийг нь

эрүүгийн хариуцлагад унагах эрсдэлтэйг төдийлөн сайн мэдэхгүй байгаагийн илрэл юм.

Хэдийгээр ОНМХ-д гэмт хэрэг, хэрэг зөрчлийн тухай нийтлэх нь шүүхээс хэргийг урьдчилан, үзэмжээрээ шийдвэрлэхэд хүргэж болзошгүй гэж үздэг ч зориуд ХМХ-ээр кампанит ажил өрнүүлээгүй нөхцөлд нийтлэл, нэвтрүүлэг шүүхээс асуудлыг шийдвэрлэхэд нөлөөлөх нь туйлын ховор тохиолддог гэсэн судалгаа бий. Гэхдээ гэмт хэргийн холбогдолтой мэдээ, ярилцлага, сурвалжлагыг эрх зүйн мэдлэгтэй, болгоомжтой хийхгүй бол заримдаа тухайн сэтгүүлчийн үзэл бодол хутгалдан явах нь элбэг байдаг.

### Дүгнэлт

Эрх зүйн мэдээллийг түгээхдээ аудиторийн хүйс, ажил мэргэжил, насыг харгалзаж, зорилгоосоо шалтгаалж, ХМХ-ээ сонгож, судалгаатай хандвал оновчтой болох нь улам бүр батлагдаж байна. Давын өмнө иргэдийн насны онцлогт тохируулан хууль эрхийн талаарх мэдлэгийг хүргэх нь ихээхэн чухал юм. Үүнийг ХМХ тус бүрт тайлбарлавал 18-30 хүртэлх насны залуучуудын ихэнх нь хууль, эрх зүйн талаарх мэдээллийг телевизээр авдаг бол нас ахих тусам энэхүү үзүүлэлт буурдгийг судалгааны дүн харуулж байна.

Хууль хэвлэх, эсвэл хууль, эрх зүй гэсэн үг орсон бүгдийг эрх зүйн мэдээлэл хэмээн авч үзэх нь өрөөсгөл юм. Иргэдийн амин чухал хэрэгцээт мэдээлэл болох эрх зүйн мэдээллийг хэрхэн яаж бэлтгэх, олон нийтэд хүргэх нь тодорхой дэг, аргачлалтай байх учиртай.

### Ишлэл

- <sup>1</sup> Нарангэрэл С. 2007. Эрх зүйн эх толь бичиг. УБ., 643 дахь тал.
- <sup>2</sup> Норовсүрэн Л. 2004. Монголын нийтлэл. Тэргүүн дэвтэр. УБ., 243 дахь тал.
- <sup>3</sup> Зулькафиль М. 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ., 108 дахь тал.

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Зулькафиль М. 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.
2. 2005. Иргэдийн эрх зүйн албан бус боловсролын эрэлт хэрэгцээний судалгааны тайлан. УБ.
3. Лүндэндорж Н. 2011. Jurisprudence. УБ.
4. 2012. Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр. УБ.
5. Нарангэрэл С. 2012. Хууль зүйн эх тайлбар толь. УБ.
6. Норовсүрэн Л. 2004. Монголын нийтлэл. Тэргүүн дэвтэр. УБ.
7. "Төрийн мэдээлэл" эмхтгэл.
8. "Хууль зүйн мэдээ" сонины 2012 оны дугаарууд.

9. "Эрх зүй" сэтгүүлийн 2012 оны дугаарууд.

10. [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)

11. [www.legalinstitute.mn](http://www.legalinstitute.mn)

### Summary

Today legislation related news and articles occupies one quarter of media related information but much of it is criminal news, criminal related news, or interview. Therefore, articles, news, and programs through media tools have lower level relevance and quality. Legal information is classified in three groups depending on its legal person who writes it and for what this law aimed for. Followings: official legal information, legal related information (has legal relevance), non-official legal information. Consequently, we can see that our periodicals report official legal information and legal related information. Literally, publications must put emphasis on non official legal information. However law articles and legal acts are important, people do not need the whole law but the parts which are associated to them and in simple words.